

Улсын нэгдсэн бүртгэлийн 2016 оны 7  
сарын 01-ны өдрийн 3652 дугаарт бүртгэв.  
Монгол Улсын Хууль зүйн яам



## ГААЛЬ, ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

16 оны 6 сарын 21 өдөр

Дугаар А/238

Улаанбаатар хот


Маягт, журам батлах тухай

Гаалийн тухай хуулийн 36.2 дахь хэсэг, 271.1.2 дахь заалт, Гааль, татварын ерөнхий газрын Захиргааны зөвлөлийн 2016 оны 06 дугаар сарын 16.-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ачааны манифест”-ын маягтыг 1 дүгээр, “Хавсралт манифест”-ын маягтыг 2 дугаар, “Тээврийн мэдүүлэг”-ийн маягтыг 3 дугаар, Автотээврийн хэрэгслийн бүртгэлийн програмд бичигдэх “Ачааны манифест”-ыг 4 дүгээр, “Ачааны манифест нөхөн бичих, хянах, бүртгэх журам”-ыг 5 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн газар /Б.Батгэрэл/-г үүрэг болгосугай.


3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Гаалийн ерөнхий газрын даргын 2011 оны 256, 2012 оны А/227 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  С.НУРЭВ

Гааль, татварын ерөнхий газрын  
даргын 2016 оны А/238 дугаар  
тушаалын 1дүгээр хавсралт

		Гааль, татварын ерөнхий газар		Ачааны манифест			1. Манифестын дугаар	
2. Барааг хилээр нэвтрүүлэх ялгаа		3. Тээвэрлэгчийн нэр		4. Тээврийн хэрэгслийн харьяалагдах улс (код)				
5. Тээвэр зууч байгууллага (код )	6. Манифест бичсэн ажилтан	7. Тээврийн хэрэгслийн дугаар	8. Манифест бичсэн огноо	9. Ачилт хийсэн газар	10. Хүлээн авах газрын нэр	11. Горимын код		
Илгээх газрын мэдээлэл		12. Гаалийн байгууллага (код )	Хүрэх газрын мэдээлэл		14. Гаалийн байгууллага (код )			
		13. Гаалийн хяналтын бүсийн код			15. Гаалийн хяналтын бүсийн код			
16. Хүрэх огноо	17. Тээврийн баримтын дугаар		18. Хавсралт манифестын тоо					
19. Барааны нэр, төрөл/ марк дугаар	20. Мэдүүлгийн дугаар		21. Илгээгчийн нэр, хаяг	22. Барааны үнийн дүн ( Валютын код )	23. Хүлээн авагчийн нэр, хаяг			
24. Дагалдах бичиг баримт	Нэр			25. Тоо хэмжээ	26. Бохир жин	27. Цэвэр жин	28. Аюултай ачааны код	
	Дугаар							
	Хуудасны тоо							
29. Чингэлэгийн дугаар (төрөл )	Чингэлэгийн ялгаа		30. Лац, ломбоны дугаар		31. Улс хоорондын тээвэр гүйцэтгэх зөвшөөрлийн дугаар			
	Чингэлэгийн жин							

Гааль, татварын ерөнхий газрын  
даргын 2016 оны А/238 дугаар  
тушаалын 2 дугаар хавсралт

	<b>Гааль, татварын ерөнхий газар</b>	<b>Хавсралт манифест</b>		<b>1. Манифестын дугаар</b>
<b>2. Барааны нэр, төрөл/ марк дугаар</b>		<b>3. Тоо хэмжээ</b>		<b>4. Цэвэр жин</b>
<b>5. Илгээгчийн нэр, хаяг</b>		<b>8. Дагалдах бичиг баримт</b>	<b>Нэр</b>	
<b>6. Хүлээн авагчийн нэр, хаяг</b>			<b>Дугаар</b>	
<b>7. Барааны үнийн дүн ( Валютын код )</b>			<b>Хуудасны тоо</b>	

Гааль, татварын ерөнхий газрын  
даргын 2016 оны А/238 дугаар  
тушаалын 3 дугаар хавсралт

## Тээврийн мэдүүлэг

1. Мэдүүлгийн №	---	2. Бичсэн огноо	
3. Мэдүүлэгч		4. Хүлээн авагч	
Нэр		Нэр	
Бүртгэлийн дугаар		Бүртгэлийн дугаар	
Мэдүүлэгчийн хаяг		Хүлээн авагчийн хаяг	
Утасны дугаар		Утасны дугаар	
5. Тээврийн төрөл	0	6. Тээврийн хэрэгслийн дугаар	
7. Газар хорооны код	0	8. Тогтоосон хугацаа	
9. Илгээсэн хяналтын бүс	0	10. Хүрэн хяналтын бүс	0
11. Дамжин өнгөрөх газар		12. Нотлох баримтын №	
13. Манифестын №		14. Тээврийн баримтын №	
15. Чингэлтийн дугаар		16. Лацийн дугаар	
17. Зориулалт			
18. Тоо хэмжээ		19. Нийт лин	20. Эзэлхүүн
	0	0.00	0.000
21. Зөвшөөрсөн мэдээлэл			

Гааль, татварын ерөнхий газрын  
даргын 2016 оны А/238 дугаар  
тушаалын 4 дүгээр хавсралт

АЧААНЫ МАНИФЕСТ  
/АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛИЙН ПРОГРАМД БИЧИГДЭХ/

1.Манифестын дугаар		2.Бүртгэсэн огноо	
---------------------	--	-------------------	--

3.Илгээсэн хяналтын бүсийн код		4.Хүрэх хяналтын бүсийн код	
--------------------------------	--	-----------------------------	--

5.Хүлээн авагчийн нэр		6.Жолоочийн нэр	
-----------------------	--	-----------------	--

7.Барааны нэр			
---------------	--	--	--

8.Лац ломбоны дугаар		9.Барааны нийт жин	
----------------------	--	--------------------	--

10.Тээврийн хэрэгслийн дугаар		11.Аралын дугаар	
-------------------------------	--	------------------	--

12.Чингэлэгийн дугаар		13.Чиргүүлийн дугаар	
-----------------------	--	----------------------	--

Гаалийн байгууллагын тэмдэглэл		
14.Илгээсэн хяналтын бүс	15.Дамжин өнгөрөх хяналтын бүс	16. Хүрэх хяналтын бүс

**АЧААНЫ МАНИФЕСТ НӨХӨН БИЧИХ,  
ХЯНАХ, БҮРТГЭХ ЖУРАМ**

1.1. Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналтад авах, ачааны манифестыг /цаашид “манифест” гэх/ нөхөн бичих, хянах, бүртгэх, дамжуулах, нэгдсэн сан үүсгэж, хяналт тавихад Гаалийн тухай хууль, холбогдох хууль тогтоомж болон энэ журмыг мөрдөнө.

1.2. Бараа, тээврийн хэрэгслийн манифестыг гаалийн байгууллагаас итгэмжлэл авсан тээвэрлэгч тээврийн хэрэгсэл тус бүрт нөхөн бичиж, барааг тээвэрлэнэ.

1.3. Тээвэрлэгч манифестын маягтын 15 дугаар хүснэгтэд бичигдсэн гаалийн хяналтын бүсэд барааг хүргэнэ.

1.4. Манифест нь хилээр нэвтрүүлж байгаа бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналтад авах бичиг баримт болно.

1.5. Нэг манифестада бичигдсэн олон нэр төрлийн барааг салгаж тээвэрлэхийг хориглоно.

1.6. Гаалийн тухай хуулийн 35 дугаар зүйлд заасан бичиг баримтын бүрэн бүтэн байдлыг тээвэрлэгч хариуцна.

1.7. Дараах төрлийн бараанд манифест бичихгүй:

-цахилгаан эрчим хүч;

-зорчигч гаалийн бүрдүүлэлт хийлгэн биедээ авч яваа бараа;

**Хоёр. Манифест нөхөн бичих**

2.1. Манифест

Хүснэгт	Хүснэгтийн нэр	Тайлбар	
1	Манифестын дугаар /12 оронтой/	Манифестын дугаарыг дараах байдлаар тайлж уншина. Жишээ нь: I0515000001A	
		Кодын орон	Утга
		1	Хилээр нэвтрэх ялгааг илэрхийлнэ. I – импорт, E - экспорт, T - транзит
		2-3	Гаалийн газар, хорооны кодыг илэрхийлнэ.
		4-5	Огноог илэрхийлнэ.
		6-11	Манифестын дугаарлалтыг илэрхийлнэ.
12	Тээврийн төрлийг илэрхийлнэ. A - агаарын зам T - авто зам R - төмөр зам		

2	Барааг хилээр нэвтрүүлэх ялгаа	Экспорт, импорт, транзит	
3	Тээвэрлэгчийн нэр	Барааг тээвэрлэж буй тээврийн байгууллагын албан ёсны нэр	
4	Тээврийн хэрэгслийн харьяалагдах улс (код)	Барааг тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн харьяагдах улсын нэр, код	
5	Тээвэр зууч байгууллага (код)	Барааны тээвэрлэлтийг зуучилж байгаа байгууллагын албан ёсны нэр, код	
6	Манифест бичсэн ажилтан	Манифест бичсэн ажилтны нэр, огноо	
7	Тээврийн хэрэгслийн дугаар	Барааг тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн дугаарыг бичнэ. Үүнд: Вагон дугаар, автомашины дугаар, онгоцны рейсийн дугаар	
8	Манифест бичигдсэн огноо	Бараанд манифест бичигдсэн огноо	
9	Ачилт хийсэн газрын код	Ачилт хийсэн улс болон хотын код, Тухайлбал: Abakan (RUABA), Xingang (CNXGG)	
10	Хүлээн авах газрын нэр, код	Тухайн барааг хүлээн авах улс, газрын код Тухайлбал: Улаанбаатар (MNULN), Эрдэнэт (MNERT), Улаангом (MNULO) гэх мэт	
11	Горимын код	Гаалийн бүрдүүлэлтийн горимын код	
Илгээх газрын мэдээлэл	12	Гаалийн байгууллага (код)	Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналтад авсан гаалийн байгууллагын нэр, код
	13	Гаалийн хяналтын бүсийн (код)	Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналтад авсан гаалийн хяналтын бүсийн нэр, код
Хүрэх газрын мэдээлэл	14	Гаалийн байгууллагын (код)	Бараанд эцсийн бүрдүүлэлт хийх гаалийн байгууллагын нэр, код
	15	Гаалийн хяналтын бүсийн (код)	Бараанд эцсийн бүрдүүлэлт хийх гаалийн хяналтын бүсийн нэр, код
16	Хүрэх огноо	Бараанд эцсийн бүрдүүлэлт хийх гаалийн хяналтын бүсэд хүрэх огноог бичнэ.	
17	Тээврийн баримтын дугаар	Тээврийн баримтын дугаарыг бичнэ. Төмөр замын тээврийн баримт Агаар тээврийн баримт /Airway bill / Автотээврийн хэрэгслийн Ачаа тээврийн дагалдах хуудас	
18	Хавсралт манифестын тоо	Үндсэн манифестаас гадна хэдэн хавсралт манифест дагалдаж байгаа тоог бичсэн.	
19	Барааны нэр, төрөл/марк дугаар	Гаалийн хилээр нэвтрүүлж байгаа барааны нэр төрлийг дагалдах бичиг баримтыг үндэслэн бичнэ. Тухайлбал: Автобензин АИ-93, түлш /өвөл, зуны/, мазут гэх мэт. Мөн бараа нь автомашин байгаа тохиодолд Барааны нэрийн ард “марк, өнгө, арлын дугаар, хөдөлгүүрийн дугаар, оноосон нэр, артикул, зориулалт болон бусад үзүүлэлтийг тус тус бичнэ.	
20	Мэдүүлгийн дугаар	Экспортлох бараанд гаалийн мэдүүлгийн дугаарыг гаалийн бүрдүүлэлтийн програмаас татна.	

21	Илгээгчийн нэр, хаяг	Бараа илгээгч аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүний нэр, утас, хаяг	
22	Барааны үнийн дүн (валютын код)	Гадаад худалдааны эсхүл тээврийн бичиг баримтад бичигдсэн үнийн дүн болон валютын код	
23	Хүлээн авагчийн нэр, хаяг	Барааг хүлээн авах аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүний нэр, утас, хаяг	
24	Дагалдах бичиг баримт	Нэр	Дагалдах баримтын нэр
		Дугаар	Баримтын дугаар
		Хуудасны тоо	Дагалдах баримтын хуудасны тоо
25	Тоо хэмжээ	Баглаа боодлын тоо, баглаа боодлын төрөл	
26	Бохир жин	Тээврийн баримтад тусгагдсан барааны нийт жин /кг/	
27	Цэвэр жин	Барааны цэвэр жин /кг/	
28	Аюултай барааны код	Химийн бодис болон галд шатамхай бодис, тэсэрч дэлбэрэх бодисын код	
29	<b>Чингэлгийн дугаар (төрөл)</b>	Чингэлгийн үсгэн тэмдэглэгээ болон тоон дугаарыг бүрэн бичнэ. Тухайлбал: ABCD123456-7, “төрөл” хэсэгт чингэлгийн даацын хэмжээг бичнэ. Тухайлбал: 3 тн, 5 тн, 10тн, 20 тн, 40 тн гэх мэт	
	<b>Чингэлгийн ялгаа</b>	“Эргэлтийн” буюу буцаан гаргах, эсхүл “Эзэмшлийн” болох ялгааг бичнэ.	
	Чингэлгийн жин	Зөвхөн чингэлгийн жин.	
30	Лац, ломбоны дугаар	Тээврийн хэрэгсэлд тавигдсан лац, ломбоны дугаарыг бичнэ. Лац, ломбо сольсон тохиолдолд эхний болон шинээр тавигдсан лац, ломбоны дугаарыг хоёуланг нь бичнэ.	
31	Улс хоорондын тээвэр гүйцэтгэх зөвшөөрлийн дугаар	Авто замаар тээвэрлэлт хийж буй тохиолдолд улс хоорондын тээвэр гүйцэтгэх зөвшөөрлийн дугаарыг бичнэ.	

## 2.2. Хавсралт манифест



Хүснэгт	Хүснэгтийн нэр	Тайлбар	
1	Манифестын дугаар /14 оронтой/	Манифестын дугаарыг дараах байдлаар тайлж уншина. Жишээ нь: <b>I-03-16-008679/07R</b>	
		Кодын орон	Утга
		1	Хилээр нэвтрэх ялгааг илэрхийлнэ. I - импорт, E - экспорт, T - транзит
		2-3	Гаалийн газар, хорооны кодыг илэрхийлнэ.
		4-5	Огноог илэрхийлнэ.
		<b><u>6-13</u></b>	<b><u>Хавсралт манифестын дугаарлалтыг илэрхийлнэ</u></b>
14	Тээврийн төрлийг илэрхийлнэ. A - агаарын зам T - авто зам R - төмөр зам		
2	Барааны нэр, төрөл/марк дугаар	Барааны нэр төрлийг дагалдах бичиг баримтыг үндэслэн бичнэ. Тухайлбал: Гутал, эмэгтэй, өвлийн гэх мэт.	
3	Тоо хэмжээ	Баглаа боодлын тоо, баглаа боодлын төрөл	
4	Цэвэр жин	Хавсралт манифестада бичигдсэн барааны цэвэр жин	
5	Илгээгчийн нэр, хаяг	Бараа илгээгч аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүний нэр, утас, хаяг	
6	Хүлээн авагчийн нэр, хаяг	Барааг хүлээн авах аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүний нэр, утас, хаяг	
7	Барааны үнийн дүн (валютын код)	Гадаад худалдааны эсхүл тээврийн бичиг баримтад бичигдсэн үнийн дүн болон валютын код	
8	Дагалдах бичиг баримт	Нэр	Дагалдах баримтын нэр
		Дугаар	Баримтын дугаар
		Хуудасны тоо	Дагалдах баримтын хуудасны тоо

**Гурав. Төмөр замын тээврийн хэрэгслээр тээвэрлэж байгаа бараанд манифест бичих, хяналт тавих**

**3.1.Төмөр замын тээврийн хэрэгслээр тээвэрлэж гаалийн хилээр оруулах бараа, тээврийн хэрэгсэлд манифестыг нөхөн бичих, хяналт тавихад дараах дарааллыг баримтална:**

3.1.1.Тээвэрлэгч нь төмөр замын тээврийн хэрэгслээр тээвэрлэж, гаалийн хилээр орох бараа тээврийн хэрэгслийн тээврийн баримт болон дагалдах бичиг баримтыг үндэслэн манифестыг нөхөн бичиж, бичлэгийг гаалийн байгууллагад сүлжээгээр илгээнэ.

3.1.2.Олон хүлээн авагчтай нэг ачилтын бараанд ерөнхий мэдээллийг тусгасан манифест, хүлээн авагч тус бүрээр хавсралт манифестыг нөхөн бичнэ.

3.1.3.Тээвэрлэгчээс илгээсэн манифестын бичлэгийг хяналт, бүрдүүлэлт хариуцсан гаалийн улсын байцаагч сүлжээгээр хянаж, барааны дагалдах бичиг баримттай нэг бүрчлэн тулган шалгана. Манифестыг алдаатай, буруу бичсэн тохиолдолд “Засварт буцаах” товч дарж, засварт буцаан, зөрчлийг арилгуулна. Манифест болон тээврийн баримтад бичигдсэн тээврийн хэрэгслийн лац, ломбоны дугаарыг тулган шалгана.

3.1.4.Манифестыг алдаагүй үнэн зөв бичсэн тохиолдолд бараа, тээврийн хэрэгсэлд шалгалт хийсэн гаалийн улсын байцаагч “Баталгаажуулах” товч дарж, мэдээллийг гаалийн улсын ахлах байцаагчид сүлжээгээр илгээнэ.

3.1.5.Гаалийн улсын ахлах байцаагч манифестын мэдээллийг шалгаж, “Зөвшөөрөх” товч дарж, манифестыг бараанд эцсийн бүрдүүлэлт хийх гаалийн хяналтын бүсэд сүлжээгээр илгээнэ.

3.1.6.Гаалийн улсын байцаагч дагалдах бичиг баримтыг дугаарлаж, дугтуйлан битүүмжилж, хувийн дугаар бүхий тэмдгээр баталгаажуулан, тээвэрлэгчид шилжүүлнэ.

3.1.7.Хилийн гаалийн байгууллагаас гүний гаалийн байгууллагын хяналтад тээвэрлэсэн барааг тээвэрлэгч гаалийн хяналтын бүсэд оруулж, гаалийн тэмдэглэгээ бүхий битүүмжлэгдсэн дугтуйг /дагалдах бичиг баримт бүхий/ гаалийн хяналтын бүс эзэмшигчид хүлээлгэн өгнө.

3.1.8.Гаалийн хяналтын бүс эзэмшигч барааг бүртгэн, гаалийн тэмдэглэгээ бүхий дугтуйг гаалийн хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагчид хүлээлгэн өгч, тухайн барааг гаалийн хяналтын бүсэд оруулах хүсэлт сүлжээгээр илгээнэ.

3.1.9.Гаалийн хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч дугтуйны битүүмжлэл алдагдсан эсэх, гаалийн тэмдэглэгээ гэмтсэн эсэхийг хянаж, зөрчилгүй тохиолдолд дугтуйг задлан, дагалдах бичиг баримтыг шалгана. Гаалийн хяналтын бүс эзэмшигчээс сүлжээгээр илгээсэн хүсэлтийг хүлээн авч, “Бүртгэх” товч дарж бүртгэн, “Зөвшөөрөх” товч дарж барааг гаалийн хяналтын бүсэд орох зөвшөөрөл өгснөөр бараа, тээврийн хэрэгсэл гүний гаалийн байгууллагын хяналтад орно.

3.1.10.Гаалийн мэдүүлгийг нөхөн бичихдээ мэдүүлгийн 51 дүгээр хүснэгтэд манифестын 12 орон бүхий дугаарыг тоон болон үсгэн тэмдэглэгээний хамт бичих бөгөөд зөв бичсэн эсэхэд бичиг баримтын бүрдүүлэлт хариуцсан гаалийн улсын байцаагч хяналт тавина.

3.1.11.Манифест дахь барааны жин нь гаалийн мэдүүлэгт бичсэн жинтэй зөрсөн тохиолдолд гаалийн хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч экспертийн магадлагаа, коммерын акт болон ачаа пүүлсэн пүүний тодорхойлолтыг үндэслэн програмд жингийн зөрүү гарсан талаар тайлбар бичнэ.

3.1.12.Манифестын 29 дүгээр хүснэгтийн “Чингэлгийн ялгаа” хэсэгт “Эзэмшлийн” гэсэн тохиолдолд чингэлэгт гаалийн мэдүүлэг нөхөн бичиж, гаалийн бүрдүүлэлт хийнэ. Гаалийн хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч програмд “Зөвшөөрөх” товч дарснаар манифест хаагдана.

3.1.13.Манифестын 29 дүгээр хүснэгтийн “Чингэлгийн ялгаа” хэсэгт “Эргэлтийн” буюу буцаан гаргах гэж бичсэн тохиолдолд манифест хаагдахгүй бөгөөд чингэлгийн мэдээлийн сан үүснэ.

3.1.14.Гаалийн хяналтын бүс эзэмшигч нь гаалийн бүрдүүлэлт хийсэн барааг гаалийн хяналтын бүсээс гаргах хүсэлтийг гаалийн хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагчид илгээх бөгөөд гаалийн хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч “Зөвшөөрөх” товч дарж, бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналтын бүсээс гаргах зөвшөөрөл өгнө.

3.1.15.Бараа, тээврийн хэрэгсэлд тухайн хилийн гаалийн байгууллагад эцсийн бүрдүүлэлт хийх тохиолдолд 3.1.2-3.1.5, 3.1.8-3.1.14-д заасныг мөрдөнө

**3.2. Төмөр замын тээврийн хэрэгслээр тээвэрлэж гаалийн хилээр гарах бараа, тээврийн хэрэгсэлд манифестыг нөхөн бичих, хяналт тавихад дараах дарааллыг баримтална:**

3.2.1.Тээвэрлэгч нь төмөр замын тээврийн хэрэгслээр тээвэрлэж, гаалийн хилээр гаргах барааны гаалийн мэдүүлгийг үндэслэн манифестыг нөхөн бичиж, бичлэгийг гаалийн байгууллагад сүлжээгээр илгээнэ.

3.2.2.“Эргэлтийн” буюу буцаан гаргах чингэлэгт бараа, тээврийн хэрэгслийг ачсан бол манифестаг бичигдсэн чингэлэгийн дугаар оруулахад “Чингэлэгийн сан” дахь тухайн чингэлэгийн мэдээлэл “Гарах” төлөвт шилжинэ.

3.2.3.Гаалийн хилээр гаргах бараа, тээврийн хэрэгсэлд манифестыг нөхөн бичих, бичлэгийг хянахад энэ журмын 3.1.3, 3.1.4-д заасныг мөрдөнө.

3.2.4.Гаалийн улсын ахлах байцаагч манифестын мэдээллийг шалгаж, “Зөвшөөрөх” товч дарж, манифестыг бараа, тээврийн хэрэгсэлд эцсийн бүрдүүлэлт хийх хилийн гаалийн хяналтын бүсэд сүлжээгээр илгээнэ.

3.2.5.Хилийн гаалийн байгууллагын хяналтад илгээсэн бараа, тээврийн хэрэгслийн дагалдах бичиг баримтыг гаалийн улсын ахлах байцаагч тээвэрлэгчээс хүлээн авч, бүртгэн, бараа, тээврийн хэрэгсэлд шалгалт хийх гаалийн улсын байцаагчийг сүлжээгээр томилно.

3.2.6.Хилийн гаалийн байгууллагын хяналт, шалгалт хариуцсан гаалийн улсын байцаагч бараа, тээврийн хэрэгслийн лац, ломбыг гаалийн мэдүүлэгтэй тулган шалгаж, зөрчилгүй тохиолдолд манифестаг “Баталгаажуулах” товч дарж, сүлжээгээр гаалийн улсын ахлах байцаагчид илгээнэ.

3.2.7.Гаалийн улсын байцаагч замын хүснэгтэд “Монголын гааль зөвшөөрөв” гэсэн хяналтын тэмдэг дарна.

3.2.8.Гаалийн улсын ахлах байцаагч сүлжээнд “Зөвшөөрөх” товч дарж бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр гаргах зөвшөөрөл өгнө.

3.2.9.Барааг төмөр замаар тээвэрлэж хилийн гаалийн байгууллагын хяналтад оруулж, тээврийн хэрэгсэл сольж, автотээврийн хэрэгслээр гаалийн хилээр гаргах тохиолдолд манифестыг дахин нөхөн бичиж, энэ журмын 3.2.2-3.2.5, 3.2.8-т заасныг мөрдөнө.

### **3.3. Төмөр замын тээврийн хэрэгслээр тээвэрлэж улс хооронд дамжуулан өнгөрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд манифестыг нөхөн бичих, хяналт тавихад дараах дарааллыг баримтална:**

3.3.1.Тээвэрлэгч нь төмөр замын тээврийн хэрэгслээр тээвэрлэж байгаа улс хооронд дамжуулан өнгөрүүлэх бараа, тээврийн хэрэгслийн дагалдах бичиг баримтыг үндэслэн манифестыг нөхөн бичиж, бичлэгийг гаалийн байгууллагад сүлжээгээр илгээнэ.

3.3.2.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх барааны манифестыг нөхөн бичих, бичлэгийг хянахад энэ журмын 3.1.3-3.1.5, 3.2.6-3.2.8-д заасныг мөрдөнө.

### **3.4.Төмөр зам болон авто тээврийн хэрэгслээр тээвэрлэгдэн гаалийн хилээр гарах чингэлэгийн манифестыг нөхөн бичих, хяналт тавихад дараах дарааллыг баримтална:**

3.4.1.Гаалийн хяналтын бүс эзэмшигч “Эргэлтийн” буюу буцаан гаргах хоосон чингэлэгийн дугаарыг “Чингэлэгийн сан”-гаас татаж, гаалийн хилээр гаргах хилийн гаалийн хяналтын бүсийн код болон холбогдох хүснэгтүүдийг нөхөн бичиж, гаалийн хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагчид сүлжээгээр илгээнэ.

3.4.2.Гаалийн хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч манифестийн мэдээллийг тээврийн бичиг баримттай тулган шалгаж, манифестыг алдаатай, буруу бичсэн тохиолдолд “Засварт буцаах” товч дарж, засварт буцаан, зөрчлийг арилгуулна.

3.4.3.Чингэлэгийн мэдээллийг гаалийн хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч тээврийн бичиг баримттай тулган шалгаж, “Зөвшөөрөх” товч дарж, чингэлэгийг гаргах хилийн гаалийн хяналтын бүсэд сүлжээгээр илгээнэ.

3.4.4.Хилийн гаалийн байгууллагын хяналтад илгээсэн хоосон чингэлэгийн дагалдах бичиг баримтыг гаалийн улсын ахлах байцаагч тээвэрлэгчээс хүлээн авч, бүртгэн, шалгалт хийх гаалийн улсын байцаагчийг сүлжээгээр томилно.

3.4.5.Хилийн гаалийн байгууллагын хяналт, шалгалт хариуцсан гаалийн улсын байцаагч чингэлгийн ломбыг тээврийн баримттай тулган шалгаж, зөрчилгүй тохиолдолд манифестадад “Баталгаажуулах” товч дарж, сүлжээгээр гаалийн улсын ахлах байцаагчид илгээнэ.

3.4.6.Гаалийн улсын байцаагч замын хүснэгтэд “Монголын гааль зөвшөөрөв” гэсэн хяналтын тэмдэг дарна.

3.4.7.Гаалийн улсын ахлах байцаагч сүлжээнд “Зөвшөөрөх” товч дарж, чингэлгийг гаалийн хилээр гаргах зөвшөөрөл өгсөнөөр импортын ачааны манифест болон хоосон чингэлгийн манифест хаагдана.

### **Дөрөв. Агаарын тээврийн хэрэгслээр тээвэрлэж байгаа бараанд манифест бичих, хяналт тавих**

4.1.Агаарын тээврийн хэрэгслээр тээвэрлэж, гаалийн хилээр оруулах барааны манифестыг нөхөн бичих, хяналт тавихад дараах дарааллыг баримтална:

4.1.1.Тээвэрлэгч агаарын тээврийн баримт болон дагалдах бичиг баримтыг үндэслэн манифестыг нөхөн бичиж, бичлэгийг гаалийн байгууллагад сүлжээгээр илгээнэ.

4.1.2.Тээвэрлэгчээс илгээсэн манифестын бичлэгийг хяналт, бүрдүүлэлт хариуцсан гаалийн улсын байцаагч сүлжээгээр хянаж, дагалдах бичиг баримттай нэг бүрчлэн тулган шалгана. Манифестыг алдаатай, буруу бичсэн тохиолдолд “Засварт буцаах” товч дарж, засварт буцаан, зөрчлийг арилгуулна.

4.1.3.Манифестыг алдаагүй үнэн зөв бичсэн тохиолдолд гаалийн улсын байцаагч “Баталгаажуулах” товч дарж, манифестыг гаалийн улсын ахлах байцаагчид сүлжээгээр илгээнэ.

4.1.4.Гаалийн улсын ахлах байцаагч манифестын мэдээллийг шалгаж, “Зөвшөөрөх” товч дарж, барааг гаалийн хяналтын бүсэд орохыг зөвшөөрнө. Гүний гаалийн байгууллагад эцсийн бүрдүүлэлт хийх тохиолдолд хүрэх хяналтын бүсэд сүлжээгээр илгээнэ.

4.1.5.Хилийн гаалийн байгууллагаас гүний гаалийн байгууллага руу тээвэрлэсэн барааг тээвэрлэгч гаалийн хяналтын бүсэд оруулж, гаалийн тэмдэглэгээ бүхий битүүмжлэгдсэн дугтуйг /дагалдах бичиг баримт бүхий/ гаалийн хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагчид өгнө.

4.1.6.Гаалийн хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч дугтуйны битүүмжлэл алдагдсан эсэх, гаалийн тэмдэглэгээ гэмтсэн эсэхийг хянаж, зөрчилгүй тохиолдолд дугтуйг задлан, дагалдах бичиг баримтыг шалгана. Гаалийн хяналтын бүс эзэмшигчээс сүлжээгээр илгээсэн хүсэлтийг хүлээн авч, “Бүртгэх” товч дарж бүртгэн, “Зөвшөөрөх” товч дарж барааг гаалийн хяналтын бүсэд орох зөвшөөрөл өгөх бөгөөд энэ үеэс бараа, тээврийн хэрэгсэл гүний гаалийн байгууллагын хяналтад орно.

4.1.7.Гаалийн мэдүүлгийг нөхөн бичихдээ мэдүүлгийн 51 дүгээр хүснэгтэд манифестын 12 орон бүхий дугаарыг тоон болон үсгэн тэмдэглэгээний хамт бичих бөгөөд зөв бичсэн эсэхэд бичиг баримтын бүрдүүлэлт хариуцсан гаалийн улсын байцаагч хяналт тавина.

4.1.8.Гаалийн хяналтын бүс эзэмшигч нь гаалийн бүрдүүлэлт хийсэн барааг гаалийн хяналтын бүсээс гаргах хүсэлтийг гаалийн хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагчид илгээх бөгөөд гаалийн улсын ахлах байцаагч “Зөвшөөрөх” товч дарж, бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналтын бүсээс гаргах зөвшөөрөл өгнө.

4.1.9.Бараа, тээврийн хэрэгсэлд тухайн хилийн гаалийн байгууллагад бүрдүүлэлт хийхэд энэ журмын 4.1.1-4.1.4, 4.1.7-4.1.8-т заасныг мөрдөнө.

4.2. Агаарын тээврийн хэрэгслээр тээвэрлэж гаалийн хилээр гаргах барааны манифестыг нөхөн бичих, хяналт тавихад дараах дарааллыг баримтална. Үүнд:

4.2.1. Тээвэрлэгч агаарын тээврийн хэрэгслээр тээвэрлэж, гаалийн хилээр гаргах бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн мэдүүлгийг үндэслэн манифестыг нөхөн бичиж, бичлэгийг гаалийн байгууллагад сүлжээгээр илгээнэ.

4.2.2. Манифестадад гаалийн байгууллага хяналт тавихдаа энэ журмын 3.2.3, 3.2.6, 3.2.8-т заасныг мөрдөнө.

4.3. Агаарын тээврийн хэрэгслээр тээвэрлэн гаалийн хилээр оруулж, тээврийн хэрэгслийн төрөл сольж, улс хооронд дамжуулан өнгөрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд манифестыг нөхөн бичих, хяналт тавихад дараах дарааллыг баримтална:

4.3.1. Тээвэрлэгч нь агаарын тээврийн хэрэгслээр тээвэрлэж байгаа улс хооронд дамжуулан өнгөрүүлэх бараа, тээврийн хэрэгслийн дагалдах бичиг баримтыг үндэслэн манифестыг нөхөн бичиж, бичлэгийг гаалийн байгууллагад сүлжээгээр илгээнэ.

4.3.2. Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх барааны манифестыг нөхөн бичих, бичлэгийг хянахад энэ журмын 3.3-д заасныг мөрдөнө.

#### **Тав. Авто тээврийн хэрэгслээр тээвэрлэж байгаа бараанд манифест бичих, хяналт тавих**

5.1. Авто тээврийн хэрэгслээр тээвэрлэн гаалийн хилээр оруулж, гүний гаалийн байгууллагад эцсийн бүрдүүлэлт хийх бараанд манифест бичих, хяналт тавихад дараах дарааллыг баримтална:

5.1.1. Тээвэрлэгч тээврийн баримт, тээврийн хэрэгслийн гэрчилгээ болон дагалдах бичиг баримтыг үндэслэн манифестыг нөхөн бичиж, бичлэгийг гаалийн байгууллагад сүлжээгээр илгээнэ.

5.1.2. Манифестадад гаалийн байгууллага хяналт тавихдаа энэ журмын 3.1.3-3.1.14-т заасныг мөрдөнө.

5.2. Гүний гаалийн байгууллагаас авто тээврийн хэрэгслээр тээвэрлэж гаалийн хилээр гаргах барааны манифестыг нөхөн бичих, хяналт тавихад дараах дарааллыг баримтална:

5.2.1. Тээвэрлэгч гаалийн мэдүүлэг, тээврийн хэрэгслийн гэрчилгээг үндэслэн манифест нөхөн бичиж, бичлэгийг гаалийн байгууллагад сүлжээгээр илгээнэ.

5.2.2. Манифестадад гаалийн байгууллага хяналт тавихдаа энэ журмын 3.2.3-3.2.6, 3.2.8-т заасныг мөрдөнө.

5.2.3. Барааг авто тээврийн хэрэгслээр тээвэрлэж, хилийн гаалийн байгууллагын хяналтад оруулж, агаарын тээврийн хэрэгслээр гаалийн хилээр гаргах тохиолдолд манифестыг дахин нөхөн бичиж, энэ журмын 4.2-т заасныг мөрдөнө.

5.3. Гаалийн нэг байгууллагаас нөгөө гаалийн байгууллагын хяналтад авто тээврийн хэрэгслээр тээвэрлэх барааны манифестыг нөхөн бичих, хяналт тавихад дараах дарааллыг баримтална:

5.3.1. Тээвэрлэгч тээврийн хэрэгслийн гэрчилгээ, дагалдах бичиг баримт, шаардлагатай тохиолдолд гаалийн мэдүүлгийг үндэслэн манифестыг нөхөн бичихэд энэ журмын 3.1.3-3.1.6-д заасныг мөрдөнө.

5.3.2. Тээвэрлэгч гаалийн тэмдэглэгээ бүхий битүүмжлэгдсэн дугтуйг /дагалдах бичиг баримт бүхий/ барааг гаалийн хяналтад хүлээн авч, гаалийн бүрдүүлэлт хийх гаалийн хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагчид өгнө.

5.3.3. Бараанд гаалийн бүрдүүлэлт хийх гаалийн байгууллага 3.1.9-3.1.11, 3.1.14-д заасныг мөрдөнө.

5.3.4. Бараанд гаалийн бүрдүүлэлт хийх байгууллагын гаалийн хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч програмд “Зөвшөөрөх” товч дарж, манифестыг хаана.

5.3.5. Гаалийн бүрдүүлэлт хийсэн барааг гаалийн байгууллага хооронд авто тээврийн хэрэгслээр тээвэрлэж, тээврийн хэрэгсэл сольж, төмөр замаар тээвэрлэн хилийн гаалийн байгууллагад илгээж, гаалийн хилээр гаргах тохиолдолд манифестыг дахин нөхөн бичиж, энэ журмын 3.2-т заасныг мөрдөнө.

5.4. Авто тээврийн хэрэгслээр тээвэрлэж улс хооронд дамжуулан өнгөрүүлэх барааны манифестыг нөхөн бичих, хяналт тавихад дараах дарааллыг баримтална. Үүнд:

5.4.1. Тээвэрлэгч бараа, тээврийн хэрэгслийн дагалдах бичиг баримтыг үндэслэн манифестыг нөхөн бичиж, бичлэгийг гаалийн байгууллагад сүлжээгээр илгээнэ.

5.4.2. Манифестыг нөхөн бичих, бичлэгийг хянахад энэ журмын 3.3-д заасныг мөрдөнө.

5.5. Авто тээврийн хэрэгслээр тээвэрлэж гаалийн хилээр оруулж, хилийн боомт дахь гаалийн хяналтын бүсэд эцсийн бүрдүүлэлт хийх ачааны манифестыг нөхөн бичих, хяналт тавихад дараах дарааллыг баримтална:

5.5.1. Гаалийн байгууллага хяналтын бүсэд оруулж байгаа ачаатай автотээврийн хэрэгслийг “Авто тээврийн хэрэгслийн бүртгэл”-ийн програмд бүртгэнэ.

5.5.2. Пүүний хэсэгт хяналт тавьж буй гаалийн улсын байцаагч авто тээврийн хэрэгслийн бүртгэлийн программд бараа, тээврийн хэрэгслийн дагалдах бичиг баримт, пүүний жинг үндэслэн барааны мэдээллүүдийг нэмж оруулан “Хадгалах” товч дарж, хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагчид сүлжээгээр илгээнэ. Авто тээврийн хэрэгслийн бүртгэлийн програмын мэдээлэл нь манифестыг орлоно.

5.5.3. Пүүний хэсэгт хяналт тавьж буй гаалийн улсын байцаагч манифестыг хэвлэн, манифестын 14 дүгээр хүснэгтэд “Гаалийн хяналтанд байгаа” тэмдэг дарж, огноог бичин, гарын үсэг зурж, хувийн дугаар бүхий тэмдгээр баталгаажуулан тээвэрлэгчид өгнө.

5.5.4. Гаалийн мэдүүлгийг нөхөн бичихдээ мэдүүлгийн 51 дүгээр хүснэгтэд манифестын 14 орон бүхий дугаарыг тоон болон үсгэн тэмдэглэгээний хамт оруулах бөгөөд дугаарыг зөв бичсэн эсэхэд бичиг баримтын бүрдүүлэлт хариуцсан гаалийн улсын байцаагч хяналт тавина.

5.5.5. Гаалийн хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч бараанд гаалийн бүрдүүлэлт хийсэн мэдээллийг хянаж, “Зөвшөөрөх” товч дарж, бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналтын бүсээс гаргах зөвшөөрөл өгнө.

5.6. Авто тээврийн хэрэгслээр тээвэрлэн гаалийн хилээр оруулж, тухайн хилийн гаалийн байгууллагын бусад хяналтын бүсэд бүрдүүлэлт хийх ачааны манифестыг нөхөн бичих, хяналт тавихад дараах дарааллыг баримтална:

5.6.1. Гаалийн хяналтын бүсэд оруулж байгаа ачаатай авто тээврийн хэрэгслийг “Авто тээврийн хэрэгслийн бүртгэлийн програм”-д бүртгэхдээ дамжих болон хүрэх хяналтын бүсийн кодыг оруулах бөгөөд энэ журмын 5.5.1-5.5.3-д заасныг мөрдөнө.

5.6.2. Хилийн хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч манифестыг хянаж, хяналтын бүсээс “Тарахыг зөвшөөрөх” товч дарж, дамжих болон хүрэх хяналтын бүсийн гаалийн улсын ахлах байцаагчид мэдээллийг сүлжээгээр илгээнэ.

5.6.3. Бараа, тээврийн хэрэгсэл дамжих хяналтын бүсийн хяналтад орох тохиолдолд дамжих хяналтын бүсийн гаалийн улсын ахлах байцаагч сүлжээгээр илгээсэн ачааны манифестыг хүлээн авч, манифестын мэдээллийг хянаж, “Орохыг зөвшөөрөх” товч дарж, гаалийн хяналтын бүсэд орох зөвшөөрөл өгнө.

5.6.4. Дамжих гаалийн хяналтын бүсийн гаалийн улсын ахлах байцаагч рентген зураг болон бусад хяналт шалгалт хийсэн тухай мэдээллийг манифестадад

хавсаргаж, “Гарахыг зөвшөөрөх” товч дарж, хүрэх гаалийн хяналтын бүсийн хяналтад илгээнэ.

5.6.5. Хүрэх гаалийн хяналтын бүсийн гаалийн улсын ахлах байцаагч манифестыг хүлээн авч “Орохыг зөвшөөрөх” товч дарж, бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналтын бүсэд оруулах зөвшөөрөл өгнө.

5.6.6. Гаалийн мэдүүлгийг нөхөн бичихдээ гаалийн мэдүүлгийн 51 дүгээр хүснэгтэд манифестын 14 орон бүхий дугаарыг тоон болон үсгэн тэмдэглэгээний хамт оруулах бөгөөд дугаарыг зөв бичсэн эсэхэд бичиг баримтын бүрдүүлэлт хариуцсан гаалийн улсын байцаагч хяналт тавина.

5.6.7. Гаалийн хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч бараанд гаалийн бүрдүүлэлт хийсэн мэдээллийг хянаж, “Зөвшөөрөх” товч дарж, бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналтын бүсээс гаргах зөвшөөрөл өгнө.

5.6.8. Гүний гаалийн байгууллагын хяналтад төмөр замын тээврийн хэрэгслээр тээвэрлэх тохиолдолд манифестыг дахин нөхөн бичиж, хяналт тавихад энэ журмын 3.1.2-3.1.10-д заасныг мөрдөнө.

### **Зургаа. Шуудан илгээмжийн манифест нөхөн бичих**

6.1. Гаалийн хилээр оруулж, шуудан илгээмжид бүрдүүлэлт хийх гаалийн хяналтын бүсэд рүү хүргэх барааны манифестыг нөхөн бичих, хяналт тавихад дараах дарааллыг баримтална.

6.1.1. Гаалийн хилээр оруулах шуудан илгээмжид манифест нөхөн бичих, хилийн гаалийн байгууллага манифестыг хянахад энэ журын 4.1.1-4.1.6-д заасныг мөрдөнө. Манифестыг бүрдүүлэлт хийх гаалийн хяналтын бүс рүү сүлжээгээр илгээнэ.

6.1.2. Шуудан илгээмжийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий байгууллага шуудан илгээмжид гаалийн хяналт, шалгалт хийлгэхээр U-POST програмыг ашиглан агаарын тээврийн баримтын 12 оронтой дугаарыг бичиж, шуудангийн гаалийн байгууллагад “Манифестын задаргаа”-г сүлжээгээр илгээнэ.

6.1.3. Гаалийн хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч дугтуйны битүүмжлэл алдагдсан эсэх, гаалийн тэмдэглэгээ гэмтсэн эсэхийг хянаж, зөрчилгүй тохиолдолд дугтуйг задлан, дагалдах бичиг баримтыг шалгана. Гаалийн хяналтын бүс хариуцсан гаалийн улсын байцаагч хилийн гаалийн байгууллагаас сүлжээгээр илгээсэн манифестын мэдээллийг шалгаж, “Бүртгэх” товч дарж бүртгэн, “Зөвшөөрөх” товч дарж шуудан илгээмжийг гаалийн хяналтын бүсэд орох зөвшөөрөл өгөх бөгөөд энэ үеэс шуудан илгээмж гүний гаалийн байгууллагын хяналтад орно.

6.1.4. Шуудан илгээмжид гаалийн хяналт, шалгалт хийх гаалийн улсын байцаагч манифестадад бичигдсэн байр ачааны тоо, жинг нягтлан шалгаж, манифестын задаргааг U-POST системээс татна. Гаалийн улсын байцаагч шуудан илгээмжийг рентген аппаратаар шалгаж, гаалийн бүрдүүлэлт хийх илгээмжийг “YES”, шуудангийн үйлчилгээ эрхлэх байгууллагад олгох илгээмжийг “NO” төлөвт оруулж, “Баталгаажуулах” товч дарна.

6.1.5. Гаалийн улсын байцаагч шуудан илгээмжид гаалийн хяналт, бүрдүүлэлт хийж сүлжээнд баталгаажуулах бөгөөд гаалийн улсын ахлах байцаагч “Зөвшөөрөх” товч дарж, бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналтын бүсээс гаргах зөвшөөрөл өгнө.

6.2. Гаалийн хилээр гаргах шуудангийн манифестыг нөхөн бичих, хяналт тавихад энэ журмын 4.2-г заасныг мөрдөнө.

### **Долоо. Тээврийн мэдүүлгийг нөхөн бичих, хяналт тавих**

7.1.Импортын манифесттай барааг гаалийн байгууллага хооронд бүрэн болон хэсэгчлэн шилжүүлэх /хаяг солих/ хүсэлтийг тээвэрлэгч тээврийн хэрэгслийн төрөл солигдох эсэхээс үл хамааран Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хяналтын асуудал хариуцсан нэгжид гаргана.

7.2.Нэг гаалийн байгууллагын гаалийн хяналтын бүс хооронд импортын манифесттай барааг шилжүүлэх хүсэлтийг тээвэрлэгч тухайн гаалийн газрын хяналт, бүрдүүлэлт хариуцсан нэгжид гаргана.

7.3.Энэ журмын 7.2-т заасны дагуу барааг шилжүүлэх дараах тохиолдолд тээвэрлэгч “Тээврийн мэдүүлгийн бүртгэл” програмын “Шалтгаан” хэсэгт шалтгааныг 20-оос доошгүй тэмдэгтээр тодорхой бичиж, гаалийн байгууллагад сүлжээгээр илгээнэ:

а.тээврийн баримтад заагдсан хүрэх хяналтын бүсийн код нь ачааны манифесттай зөрсөн,

б.химийн болон цацраг идэвхт, тэсэрч дэлбэрэх аюултай ачааг тусгайлан тогтоосон гаалийн хяналтын бүсэд оруулах,

в.олон манифесттай иж бүрдэл барааг салгаж өөр өөр гаалийн хяналтын бүсэд илгээсэн,

г.гаалийн хяналтын бүсийн техникийн хүчин чадлаас шалтгаалан хүлээн авах боломжгүй болсон.

7.4. Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тээврийн хэрэгслийн хяналтын асуудал хариуцсан нэгж эсхүл тухайн гаалийн газар хорооны гаалийн хяналт, бүрдүүлэлт хариуцсан нэгж тээврийн мэдүүлгийг хүлээн авч хянаж “Зөвшөөрөх”, манифестын нэгдсэн санд зохих тайлбар бичин “Татгалзах” эсхүл “Засварт буцаах” шийдвэрийн аль нэгийг гаргана.

7.5.Тээврийн мэдүүлэгт “Зөвшөөрөх” товч дарахад тээврийн мэдүүлгийг тээвэрлэгч хэвлэх боломжтой болох бөгөөд хүлээн авах гаалийн хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагчид сүлжээгээр илгээгдэнэ.

7.6.Барааг хэсэгчилэн шилжүүлэхээр тээврийн мэдүүлэг бичигдсэн тохиолдолд манифестын бохир жин, тоо хэмжээнээс тээврийн мэдүүлэгт бичигдсэн хэмжээгээр хасагдаж, гаалийн хяналтын бүс хариуцсан гаалийн улсын байцаагчид үлдэгдэл бүхий манифест харагдана.

7.7.Тээвэрлэгч тээврийн мэдүүлгийг 1 хувь хэвлэнэ. Тээврийн мэдүүлэгт гаалийн улсын байцаагч “Гаалийн хяналтад байгаа” тэмдэг дарж, дагалдах бичиг баримтыг дугаарлаж, дугтуйлан битүүмжилж, хувийн дугаар бүхий тэмдгээр баталгаажуулан, тээвэрлэгчид шилжүүлнэ.

7.8.Тээвэрлэгч барааг хүлээн авах гаалийн хяналтын бүсэд оруулж, тээврийн мэдүүлэг болон гаалийн тэмдэглэгээ бүхий битүүмжлэгдсэн дугтуй /дагалдах бичиг баримт бүхий/-г гаалийн хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагчид хүлээлгэн өгнө.

7.9.Гаалийн улсын ахлах байцаагч тээврийн мэдүүлэгт “Зөвшөөрөх” товч дарна. Гаалийн хяналтын бүс эзэмшигч импортын манифестыг бүртгэж, гаалийн хяналтын бүсэд оруулах хүсэлтийг гаалийн хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагчид сүлжээгээр илгээнэ.

7.10.Тээврийн мэдүүлэг бүхий барааг Гаалийн итгэмжлэл авсан тээвэрлэгч тээвэрлэнэ.

## **Найм. Бусад**

8.1.Гаалийн баталгаат болон чөлөөт бүсийн горимд байршиж байгаа бараа, тээврийн хэрэгслийг гаалийн нэг байгууллагаас гаалийн өөр байгууллагын хяналтад шилжүүлэхэд энэ журмын 5.3-ыг мөрдөнө.



8.2. Барааг хилийн чанадад гаргах гаалийн бүрдүүлэлтийн горимд байршуулсан барааг тухайн горимд байршуулахаас гаалийн байгууллага татгалзсан эсхүл тодорхой шалтгааны улмаас хилээр гаргах боломжгүй болсон тохиолдолд гаалийн мэдүүлэгт гаалийн улсын ахлах байцаагч “Татгалзах” төлөвийг сонгосны дараа ачааны манифестадад мөн “Татгалзах” төлөвийг сонгож “Тайлбар” хэсэгт шалтгааныг бичсэнээр манифест хаагдана.

8.3. Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тээврийн хэрэгслийн хяналтын асуудал хариуцсан нэгжийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөн хариуцсан гаалийн улсын байцаагч ачааны манифестын санд хяналт тавьж ажиллана.

8.4. Гаалийн хилээр орох бараа, тээврийн хэрэгслийн ачааны манифестын 10, 14, 15, 19, 22-27 дугаар хүснэгтүүдээс /хүлээн авах газрын код, хүрэх гаалийн газрын мэдээлэл, барааны нэр, барааны үнэ, валютын код, дагалдах бичиг баримт, тоо хэмжээ, цэвэр жин, бохир жин/ бусад хүснэгтэнд оруулах засварыг тээвэрлэгч хийж, Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хяналтын асуудал хариуцсан нэгж баталгаажуулна.

8.5. Тээвэрлэгч нь ачааны манифестадад засвар оруулахдаа манифестын програмын “Тайлбар” хэсэгт засвар оруулах болсон шалтгааныг тодорхой, үнэн зөв бичнэ.

8.6. Манифестыг нөхөн бичих, хяналт тавихтай холбоотой гарсан зөрчлийг эцсийн бүрдүүлэлт хийж байгаа гаалийн газар, хороо шийдвэрлэж, сар бүрийн 10-ны дотор зөрчлийн тайланг гаргаж, Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хяналтын асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ.

8.7. Манифестыг нөхөн бичих, хянах, бүртгэх журмыг зөрчсөн, манифестын бичлэгийг зөвшөөрөлгүйгээр засварласан, устгасан, мэдээг сүлжээгээр буруу дамжуулсан, дамжуулахгүй саатуулсан буруутай этгээдэд Гаалийн хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

8.8. Энэхүү журмаар зохицуулагдаагүй бусад асуудлыг гаалийн хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

---oOo---